



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/358

Булган сум

### Ажлын хэсэг байгуулах, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймагт Цагдаа, дотоодын цэргийн байлдааны тугийг залж аялуулж хүндэтгэл үзүүлэх ажлын хүрээнд цагдаа дотоодын цэргийн үйл ажиллагааг хүүхэд, залуучууд, иргэдэд танилцуулах, тусгаар тогтнол, үндэсний эв нэгдэл, эрх чөлөөний үнэ цэнийг ойлгуулах, эх байгаль, түүх соёлоо хайрлан хамгаалах, эрх оронч иргэнийг төлөвшүүлэх зорилгоор цагдаа, дотоодын цэргийн тугийг аялуулах, ёслолын жагсаал, арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Ганбаатар (Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа)

Гишүүдэд:

- Ч.Энхбаяр (Цэргийн штабын дарга, Дэд хурандаа)
- Ш.Баасандорж (Онцгой байдлын газрын дарга, Хурандаа)
- Д.Төгсбаяр (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, Хурандаа)
- П.Цогбадрах (Шүүх шинжилгээний хэлтсийн дарга, Хошууч)
- М.Эрдэнэбуян (Хилийн цэргийн 0286 дугаар ангийн захирагч, Хурандаа)
- Д.Эрдэнэбаяр (Зэвсэгт хүчний 0234 дүгээр ангийн захирагч, Хурандаа)
- Д.Батгэрэл (0439 дүгээр хаалттай хорих ангийн захирагч, Хурандаа)

2.Цагдаа, дотоодын цэргийн байлдааны туг залах, аялуулах, хүндэтгэл үзүүлэхтэй холбоотой бусад арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллаж, тайлан мэдээг ирүүлэхийг ажлын хэсэг (Цагдаагийн хурандаа Л.Ганбаатар)-т даалгасугай.

3. Уг арга хэмжээнд зориулж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 3,500 000 (Гурван сая таван зуун мянга) төгрөг зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай) –д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ